



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 0495

Жавхлант

Г Биеийн тамир спортын талаар авах
зарим арга хэмжээний тухай Г

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3, Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын 6.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагууд дээр биеийн тамир, спорт хариуцах албан тушаалтны нэрсийг 1 дүгээр хавсралтаар, Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 онд зохион байгуулах биеийн тамир, спортын тэмцээн уралдааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, Баг, ААН, төрийн болон төрийн бус байгууллагуудын заал авах хуваарийг 3 дугаар хавсралтаар, ажлын байранд дасгал хөдөлгөөн хийх хуваарийг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж, нийгмийн бодлогын мэргэжилтэн (Э.Хонгорзул)-д ирүүлэхийг байгууллагуудын биеийн тамир, спорт хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажилтан, албан хаагч тус бүрээр үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ч.Болормаа), Цэцэрлэгийн эрхлэгч (Ц.Энхмаа), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ж.Бавуудорж), Соёлын төвийн дарга (И.Эрдэнэтуяа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАТЧУЛУУН

